



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 1,245,797,191.00 (нэг тэрбум хоёр зуун дөчин таван мянга долоон зуун ерэн долоон мянга нэг зуун ерэн нэгэн) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Булган аймгийн (орон нутгийн) өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож (холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт) бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Булган аймгийн орон нутгийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /тегрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Ахмадын өргөөний барилга /Булган аймаг, Булган сум, 5-р баг/	2 давхар, зоорьтой, нийт 827,84м2, ашигтай 631,55м2	1,245,797,191.00	2021-11-08 УҚД- 22/2021
	Нийт дүн		1,245,797,191.00 (нэг тэрбум хоёр зуун дөчин таван мянга долоон зуун ерэн долоон мянга нэг зуун ерэн нэгэн)	